

**ШУА-ИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР (PhD),
ДЭД ПРОФЕССОР Д.ЗОЛБООГИЙН
ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ**

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Юуны өмнө бид бүхний урилгыг хүлээн авч, “Олон улс судлал 2020: Монголын хятад судлал” эрдэм шинжилгээний хуралд цахимаар оролцож буй эрхэм хүндэт судлаач, эрдэмтэн, багш нартаа гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Энэ удаагийн манай хурлын нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн тэргүүн дэд Ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал Т.Батцэцэг нар оролцож байгааг дуулгаж байгаадаа баяртай байна.

Манай хүрээлэн 1968 онд анх байгуулагдахдаа “Дорно дахин” судлал буюу тэр дундаа Хятад судлалын суурьтай ажиллаж байсныг та бүхэн мэднэ. Улмаар 2000 оноос хүрээлэнгийн үйл ажиллагаа өргөжин тэлэх үест “Олон улс судлал” сэдэвт хурлыг тухайн үед жил бүр зохион байгуулдаг байлаа. Энэ уламжлалаа бид сэргээн 2019 онд зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч цаг хугацааны хувьд бага зэрэг хойшлон өнөөдөр хэрэгжүүлж байгааг ойлгон хүлээн авч байгаад талархаж байна.

Хурлын үйл ажиллагааг үндсэндээ манай хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэмтэн судлаачид хариуцан ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсад Хятад судлалын чиглэлээр ажилладаг Стратеги судалгааны хүрээлэн, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, ШУА-ийн Философийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Дотоод Хэргийн Их Сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн эрдэмтэн багш нарын төлөөлөл оролцож байгаад бид маш баяртай байна.

Өнөөдрийн хуралд бид *нэгдүгээрт*, улс төр, эдийн засаг, шашин, гүн ухаан, *хоёрдугаарт*, гадаад бодлого, аюулгүй байдал, *гуравдугаарт*, Монгол-Хятадын харилцаа: түүх улс төр, эдийн засаг болон шинжлэх ухаан, боловсрол гэсэн ерөнхий 4 чиглэлээр ангилсан 20 гаруй илтгэлийг сонсож, хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хүрээлэнгийн захиргаа “Олон улс судлал” хурлыг цаашид жил бүр тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд илтгэл, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг багтаасан эмхэтгэлийг албан хэрэгцээнд цөөн тоогоор хэвлүүлж байхаар төлөвлөж байгаагаа Та бүхэнд сонордуулья.

Хөтөлбөрийн дагуу манай эрдэм шинжилгээний хурлыг нээж үг хэлнэ үү хэмээн академич Г.Чулуунбаатар, ГХЯ-ны Хөрш орнуудын газрын дарга Т.Батцэцэг нарыг урьж байна.